**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/115/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Т.Намжил<br>Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.15 № УВА-2023/115/НА-СТА-ЗНЗ
танай ________ -ны № ________ -т

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.ОРШИХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал өөрчлөгдсөн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000535

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........ 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........ 10

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа........ 10

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин........ 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........ 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт........ 11

4. Аудитын тайлан ........ 14

4.1 Ерөнхий зүйл ........ 14

4.2 Материаллаг байдал ........ 14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........ 14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15

5. Аудитын илрүүлэлт ........ 16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **113,692,679.83** | **182,424,061.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 70,405,503.71 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 70,405,503.71 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 70,405,503.71 |
| **33** | **АВЛАГА** | **2,810,648.00** | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,640,648.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,170,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,170,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 110,882,031.83 | 112,018,557.59 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,728,827.60 | 7,715,353.36 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,663,427.60 | 7,715,353.36 |
| 35130 | Эм боох материал | 65,400.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 104,153,204.23 | 104,303,204.23 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,769,500.00 | 1,919,500.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 300,000.00 | 300,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 102,083,704.23 | 102,083,704.23 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 2,463,494,450.38 | 2,464,499,129.44 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,463,494,450.38 | 2,464,499,129.44 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,712,641,116.98 | 1.714,039,129.44 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,502,458,955.00 | 1,502,458,955.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -60,244,808.34 | -94,747,390.86 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31,350,000.00 | 31,350,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -3,265,625.00 | -7,184,375.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 432,511,875.70 | 450,388,369.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -298,538,634.87 | -274,430,457.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 160,090,343.90 | 159,811,845.67 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -81,365,585.34 | -88,024,448.71 |
| 39209 | Бусад үндсэн хөрөнгө | 9,705,900.00 | 9,705,900.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -9,705,900.00 | 9,705,900.00 |
| 39217 | Ном | 29,644,595.93 | 34,416,630.73 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 750,853,333.40 | 750,460,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,850,000.00 | 2,850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,216,666.60 | -2,610,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 750,220,000.00 | 750,220,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 2,577,187,130.21 | 2,646,923,190.74 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 241,356.00 | 3,501,193.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 241,356.00 | 3,501,193.00 |
| **411** | **Богино хугацаат үнэт цаас** | 00.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 241,356.00 | 3,501,193.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 141,356.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 100,000.00 | 3,501,193.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 3,501,193.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 100,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,576,945,774.21** | **2,643,421,997.74** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,576,945,774.21 | 2,643,421,997.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,368,870,237.65 | 1,368,870,237.65 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,368,870,237.65 | 1,368,870,237.65 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 979,736,586.90 | 1,046,212,810.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 979,736,586.90 | 979,736,586.90 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 66,476,223.53 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 228,338,949.66 | 228,338,949.66 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,577,187,130.21** | **2,646,923,190.74** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,003,851,267.46** | **2,112,042,290.56** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **1,992,351,711.46** | **54,888,490.56** |
| **110** | **Орлогын албан татвар** | 339,465,811.46 | 54,888,490.56 |
| **1100** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | 259,609.00 | 8,143,530.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 259,609.00 | 7,269,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 873,630.00 |
| | Бусад орлого | | 35,000.00 |
| | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үнсэн хөрөнгө | 301,116,342.96 | 45,658,034.80 |
| | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал | 38,089,859.50 | 1,051,925.76 |
| | **Тусламжийн орлого** | **201,948,100.00** | |
| | Төсвөөс санхүүжих | 201,948,100.00 | |
| | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **1,450,937,800.00** | |
| | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,450,937,800.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **11,499,556.00** | **2,057,153,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 1,812,955,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,812,955,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,499,556.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,600,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 899,556.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 244,198,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 244,198,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,716,195,939.34** | **2,045,474,400.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,716,195,939.34** | **2,045,474,400.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,664,102,791.34 | 1,930,074,212.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,184,465,082.00 | 1,393,705,359.24 |
| 210101 | Үндсэн цалин | 780,575,499.00 | 1,105,786,750.24 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 328,314,883.00 | 247,137,598.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 75,574,700.00 | 40,781,011.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,545,531 | 173,050,420.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 108,886,099.00 | 118,552,145.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,935,200.00 | 13,945,742.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,466,732.00 | 11,143153.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,387,100.00 | 2,667,538.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,870,400.00 | 26,741,840.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 192,614,380.00 | 197,341,113.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,425,826.00 | 11,224,265.56 |
| 210302 | Түлш, халаалт | 182,795,036.00 | 181,389,332.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,393,518.00 | 4,727,516.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,020,983.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | 5,110,366.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,134,200.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,588.300.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 6,000.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,001,950.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,314,800.00 | |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 24,865,367.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 429,200.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 429,200.00 | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,384,900.00 | 8,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 9,384,900.00 | 8,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 641,000.00 | |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 641,000.00 | |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,130,830.00 | 17,073,772.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,856,430.00 | 4,500,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 418,000.00 | 12,573,772.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 74,870,885.34 | 140,903,548.07 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 31,889,940.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,057,350.00 | 19,501,919.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,813,535.34 | 89,511,689.07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 52,093,148.00 | 115,400,187.44 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,861,150.00 | 115,291,700.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,739,150.00 | 114,121,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,122,000.00 | 1,170,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,231,998.00 | 108,487.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,231,998.00 | 108,487.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **287,655,328.12** | **66,567,890.20** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 19,863,090.59 | 91,666.67 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 19,863,090.59 | 91,666.67 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -19,863,090.59 | -91,666.67 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **267,792,237.53** | **66,476,223.53** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,664,645,065.00** | **2,065,332,330.00** |
| | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,653,145,509.00** | **8,143,530.00** |
| | **Нийтлэг татварын бус орлого** | 259,609.00 | 8,143,530.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 259,609.00 | 8,143,530.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 259,609.00 | 7,269,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 873,630.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 201,948,100.00 | |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 201,948,100.00 | |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 1,450,937,800.00 | |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,450,937,800.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **11,499,556.00** | **2,057,188,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 1,812,955.000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,812,955,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,499,556.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,600,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 899,556.00 | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 244,198,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 244,198,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | | 35,000.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | 35,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,664,645,065.00** | **1,994,926,826.29** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,664,645,065.00** | **1,994,926,826.29** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,611,381,917.00** | **1,880,696,638.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,186,706,510.00 | 1,392,279,465.67 |
| 210101 | Үндсэн цалин | 768,583,610.00 | 958,130,677.83 |
| 210102 | Нэмэгдэл | 342,548,200.00 | 385,843,950.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 75,574,700.00 | 48,304,837.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 158,186,179.00 | 173,077,021.62 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 110,445,379.00 | 118,578,746.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,935,200.00 | 13,945,742.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,548,100.00 | 11,143,153.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,387,100.00 | 2,667,538.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,870,400.00 | 26,741,840.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 192,847,700.00 | 193,839,920.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,425,826.00 | 7,723,072.56 |
| 210302 | Түлш, халаалт | 183,028,356.00 | 181,389,332.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,393,518.00 | 4,727,516.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,525,456.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | 1,631,956.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,134,200.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,588,300.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 783,700.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,600,100.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,787,200.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 1,530,300.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 364,400.00 | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,165,900.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 32,596,382.00 | 8,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,000,000.00 | |
| 210602 | Тавилга | 5,495,982.00 | |
| 210604 | Урсгал засвар | 9,100,400.00 | 8,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 641,000.00 | |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 641,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,546,330.00 | 17,073,772.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,971,930.00 | 4,500,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 718,000.00 | 12,573,772.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,802,060.00 | 96,426,459.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 76,806,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,802,060.00 | 19,620,219.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,263,148.00** | **114,230,187.44** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,031,150.00 | 114,121,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,739,150.00 | 114,121,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,292,000.00 | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,231,998.00 | 108,487.44 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,231,998.00 | 108,487.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | | **70,405,503.71** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | 70,405,503.71 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 70,405,503.71 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/эмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 618,650,237.65 | 367,596,036.93 | 110,153,627.64 | | 1,096,399,902.22 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **618,650,237.65** | **367,596,036.93** | **110,153,627.64** | | 1,096,399,902.22 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -71,344,213.31 | | -71,344,213.31 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,368,870,237.65** | **228,338,949.66** | **979,736,586.90** | | 2,576,945,774.21 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-** | **1,368,870,237.65** | **228,338,949.66** | **979,736,586.90** | | 2,576,945,774.21 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **нээрх үлдэгдэл** | | | | | |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,368,870,237.65** | **228,338,949.66** | **979,736,586.90** | | 2,576,945,774.21 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | | 66,476,223.53 | | 66,476,223.53 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,368,870,237.65** | **228,338,949.66** | **1,046,212,810.43** | | 2,643,421,997.74 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| ЭЗА | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,065,027,400.00 | 1,994,818,338.85 | 70,209,061.15 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,065,027,400.00 | 1,994,818,338.85 | 70,209,061.15 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,945,152,700.00 | 1,880,696,638.85 | 64,456,061.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,416,821,300.00 | 1,392,279,465.67 | 24,541,834.33 |
| 210101 | Үндсэн цалин | 1,074,646,600.00 | 958,130,677.83 | 116,515,922.17 |
| 210102 | Нэмэгдэл | 329,700,700.00 | 385,843,950.84 | -56,143,250.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,412,300 | | 2,412,300 |
| 210104 | Урамшуулал | 10,061,700.00 | 48,304,837.00 | -38,243,137.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 177,200,300.00 | 173,077,021.62 | 4,123,278.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 120,496,200.00 | 118,578,746.76 | 1,917,453.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,176,000.00 | 13,945,742.12 | 230,257.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,340,800.00 | 11,143,153.46 | 197,646.54 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,835,200.00 | 2,667,538.59 | 167,661.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,352,100.00 | 26,741,840.69 | 1,610,259.31 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 193,948,100.00 | 193,839,920.56 | 108,179.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,500,000.00 | 7,723,072.56 | -2,223,072.56 |
| 210302 | Түлш, халаалт | 182,856,000.00 | 181,389,332.00 | 1,466,668.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,592,100.00 | 4,727,516.00 | 864,584.00 |
| 210304 | Байрны түрээс | | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,000,000.00 | 8,000,000.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,581,500.00 | 17,073,772.00 | 507,728.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,500,000.00 | 4,500,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,081,500.00 | 12,573,772.00 | 507,728.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 131,601,500.00 | 96,426,459.00 | 35,175,041.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,979,200.00 | 76,806,240.00 | 35,172,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,622,300.00 | 19,620,219.00 | 2,081.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 119,874,700.00 | 114,121,700.00 | 5,753,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 119,874,700.00 | 114,121,700.00 | 5,753,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 119,874,700.00 | 114,121,700.00 | 5,753,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,065,027,400.00 | 2,065,332,330.00 | -304,930.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,812,955.000.00 | 1,812,955,000.00 | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,812,955,000.00 | 1,812,955,000.00 | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 244,198,800.00 | 244,198,800.00 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 244,198,800.00 | 244,198,800.00 | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 7,873,600.00 | 8,143,530.00 | -269,930.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,750,000.00 | 7,269,900.00 | -1,519,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,123,600.00 | 873,630.00 | 1,249,970.00 |
| **14** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | | 35,000.00 | -35,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 70,405,503.71 | -70,405,503.71 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | | | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 610001 | Төсвийн байгууллага | | | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | | | 88 |
| 620001 | Удирдах ажилтан | | | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | | 73 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | 14 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багшийн хөгжлийг дэмжин сургалтын чанарыг сайжруулж, хүүхэд бүрийн сурч хөгжих боломжийг бүрдүүлэх зорилготой байгууллага юм.

*Зорилт нь:*

1. Суралцагчдын хичээлийн хоцрогдлыг бууруулан сурч хөгжих боломжийг бүрдүүлэх
2. Хичээл сургалт болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагчдын ур чадварыг хөгжүүлэх
3. Дунд, ахлах ангийн суралцагчдын мэргэжил, хичээл сонголтод мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, технологийн дэвшил ашиглан суралцах боломжийг бүрдүүлж, сургалтын арга хэлбэрийг хөгжүүлэх
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх
5. Багш нараа олон хэлбэрт сургалт, үйл ажиллагаагаар хөгжүүлэх , ахмад болон зөвлөх багш нарын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах
6. Багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн хамт олны харилцааны эерэг хандлага, соёлыг бий болгох
7. Хүүхдийг зөв зохистой дадал хэвшилд сургаж, шим тэжээллэг хоол хүнсээр ханган, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах
8. Сургуульд суурилсан менежментийг сайжруулах
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай байдал, хэрэгцээ шаардлагыг судлан боловсролд тэгш хамруулах
10. Улсын төсвөөс олгох хувьсах зардлын санхүүжилтийг зориулалтын дагуу хамт олны оролцоотой төлөвлөж, хэрэгжилтийн үр дүнг ил тод, нээлттэй тайлагнах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулахад Боловсролын хууль, Хөдөлмөрийн хууль, Төсвийн хууль, Бага дунд боловсролын хууль зэрэг хууль тогтоомжийг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3-р сургуульд тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна. Дотоод аудитаас дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна. Тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,736.1 мянган төгрөгөөр буюу 27.0 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 70,405.5 | 70,405.5 |
| Авлага | 2,810.6 | 0.0 | -2,810.6 |
| Бараа материал | 110,882.0 | 112,018.5 | 1,136.52 |
| Үндсэн хөрөнгө | 2,463,494.4 | 2,464,499.1 | 1,004.7 |
| **Нийт хөрөнгө** | **2,577,187.1** | **2,646,923.2** | **69,736.1** |
| Өр төлбөр | 241.3 | 3,501.2 | 3,259.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,576,945.8 | 2,643,422.0 | 66,476.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,577,187.1** | **2,646,923.2** | **69,736.1** |

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 70,405.5 мянган төгрөг болж нэмэгдсэнд нөхөн хангалтын зардалд ирсэн мөнгөний үлдэгдэл, зарцуулагдаагүй төсвийн хэмнэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 2,810.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн хувь хүнээс авах авлага барагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 112,018.5 мянган төгрөг болж 2,810.6 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй ирсэн ном болон аж ахуйн материалын үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,464,499.1 мянган төгрөг болж 1,004.7 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө нэмэгдэж үндсэн хөрөнгө акталсан болон элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 44,950.0 мянган төгрөгөөр тоног, төхөөрөмж худалдан авсан, 45,658.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ном, сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 68,238.0 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр 89,511.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,501.2 мянган төгрөг болж 3,259.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд шинээр үүссэн цахилгааны өр төлбөрөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,643,422.0 мянган төгрөг болж 66,476.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн 1,899,454.8 мянга, үйл ажиллагааны орлогоос 2,500.0 мянга, нийт орлогыг 1,901,954.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,901,954.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн зардлыг 502,929.2 мянган төгрөгөөр бууруулж 2022 онд улсын төсвөөс 1,399,025.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ боловсрол шинэчлэлийн хүрээнд зардлын зүйл ангийг өөрчилсөнтэй холбоотой зарим зардлыг танасан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нэмэгдүүлэн нийт 2,065,027.4 мянган төгрөг болгож тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,812,955.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 244,198.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 7,873.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,812,955.0 мянга, орон нутгийн төсвөөс 244,198.8 мянга, өөрийн орлогоос 8,178.5 мянга, нийт 2,065,332.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,994,818.3 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байна. Тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 108.5 мянган төгрөгийг төвлөрүүлжээ. Мөн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 70,405.5 мянган төгрөг байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын зардал | 5,232.6 | 5,112.4 | 120.20 | 97.7 |
| 2 | Сургалтын зардал | 2,616.3 | 903.2 | 1,713.10 | 34.5 |
| 3 | Эрүүл мэндийн арга хэмжээ | 6,017.5 | 5,982.0 | 35.50 | 99.4 |
| 4 | Үдийн цай хөтөлбөр | 119,874.7 | 114,121.7 | 5,753.00 | 95.2 |
| 5 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 76,425.0 | 44,950.0 | 31,475.00 | 58.8 |
| 6 | Багш хөгжлийн зардал | 11,773.4 | 11,280.2 | 493.20 | 95.8 |
| 7 | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх | 1,493,813.7 | 1,467,433.6 | 26,380.10 | 98.2 |
| 8 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 97,201.8 | 94,113.3 | 3,088.50 | 96.8 |
| 9 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах | 3,373.6 | 2,331.6 | 1,042.00 | 69.1 |
| 10 | Сурах бичгийн түрээс | 4,500.0 | 4,500.0 | 0.00 | 100.0 |
| 11 | Байр ашиглалттай холбоотой зардал | 201,948.1 | 201,839.9 | 108.20 | 99.9 |
| 12 | Нийтлэг үйлчилгээ | 42,250.7 | 42,250.4 | 0.30 | 100.0 |
| | Нийт дүн | 2,065,027.4 | 1,994,818.3 | 70,209.1 | 96.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 9 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8,580.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,045,474.4 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 10,227.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,181.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн хэлтсийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 147, хугацаа хоцроосон мэдээлсэн 2, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Улаангом сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчил илрээгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил гараагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /Т.НАМЖИЛ/

2023 оны 02 сарын 14-ний өдөр